

Оюу толгой

Их говийн аялгуу



Их говийн аялгуу

Үлэг гүрвэлийн мөрийг өвлөн хадгалсан өмнийн цэнхэр говь үлгэрийн гайхамшигт нутаг билээ. Тэлмэн зэрэглээ наадаж, тэмээн сүрэг бэлчсэн шаргал говь нь байгалийн өвөрмөц тогтоц, ховор амьтан, ургамлын ертөнц, түүх, соёлын гайхамшигт өв, эртний ховор нандин дурсгалт зүйлсийн өлгий.

Тэнд өвгөд дээдсийн минь үр хойчдоо өвлүүлэн үлдээсэн Оюу толгой хэмээх алт, зэсийн баялаг орд байдаг. Монгол улсын Засгийн газар олон улсын хөрөнгө оруулагчидтайгаа хамтарч, энэхүү баялаг ордыг түшиглэж уурхайн иж бүрэн цогцолбор барьж байгуулан ашиглалтад оруулснаар улс орон урагшлан хөгжихөд хувь нэмрээ оруулж байна. “Оюу толгой” нийгмийн хариуцлагатай компани учраас говь нутаг, говийнхны аж төрөх ёс, түүх, соёлын өв, байгаль орчинг хамгаалах, боловсрол, эрүүл мэндийн чиглэлд онцгойлон анхаарч, цөөнгүй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг юм. Бид соёлын өвийг хамгаалах хөтөлбөрийнхөө хүрээнд ардын аман зохиол, үлгэр домог, дуу хөгжим, дүрслэх урлагийн өв санг бүртгэх, сэргээх, сүдлах чиглэлд анхаарал тавьдгаас гадна орчин цагийн сонгодог урлагийн хөгжлийг ч дэмждэг.

Эрхэм сонсогч танд “Их говийн аялгуу” хэмээх энэхүү цомогт “Оюу толгой” компанийн тусгай захиалгаар Монгол улсын Төрийн хошой шагналт, Ардын жүжигчин Н.Жанцанноровын бүтээсэн “Оюу эрдэнийн говь” симфони чуулбарыг толилуулж байна. Энэхүү чуулбар нь “Их өглөө”, “Хулангийн тоос”, “Зэрэглээ”, “Угалз”, “Сэтгэлийн гүнээс”, “Ханбогдын эгшиглэн”, “Эрин цаг” хэмээх долоон ангиас бүрдсэн юм. Чихнээ яруу эгшиглэх энэхүү чуулбарыг сонсоход үзэсгэлэн төгөлдөр говиор аялах зуураа тэнд өрнөж буй эрин зууны бүтээн байгуулалтын анир чимээг мэдрэх буй за.

Мөн Элчин сайд Г.Батсүхийн шүлэг, Соёлын гавьяат зүтгэлтэн Л.Балхжавын хөгжим “Оюу толгой” дууг уг цомогт шингээсэн болно.

Таалан соёрхож, таашаан сонсоно уу.



Melody of the Gobi

The southern Gobi Desert is a magnificent place. Herds of camel roam through rippling mirages, and the golden sands are home to unique natural formations, rare animals and plants, and stand as symbols of a spectacular history and cultural heritage.

Located deep in the Gobi is Oyu Tolgoi, a rich gold and copper deposit that we have inherited from our ancestors. The Government of Mongolia and international investors constructed and commissioned the Oyu Tolgoi mine complex to realise the rich deposit, which is expected to play a significant role in the development of Mongolia. Since its inception, Oyu Tolgoi LLC has committed itself to protecting and supporting the Gobi region, its customs, environment, history and cultural heritage. Considerable efforts are underway to record, restore and research folklore, legend, music and fine art, as well as to support the development of contemporary classical art.

Melody of the Gobi includes *Turquoise Gobi*, a symphony ensemble composed by Mongolian State Merited Performer and People's Artist N. Jantsannorov at the request of Oyu Tolgoi. The ensemble consists of seven parts: *Great Morning*, *Khulan Dust*, *Mirage*, *Gobi Storm*, *From the Bottom of the Heart*, *Khanbogd Melody* and *New Era*.

The album also includes *Oyu Tolgoi*, with lyrics by Ambassador G. Batsukh and music by Cultural Merited Artist L. Balkhjav.

We hope this harmonious ensemble will take you on a journey to the beautiful Gobi, and introduce you to the new era of development taking place there.

Enjoy!



Шүлэг:
Элчин сайд Г.Батсүх

Ая:
Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Л.Балхжав

Оюу толгой

Түмэн галавын чанадаас ундарсан
Түүхийн туршид ургаж цогцолсон
Эцэг дээдэс минь үүцэлж хадгалсан
Элэнц хуланцаас нууцалж өвлөсөн
 Өмнийн говийн эрдэнэсийн өлгий
 Өнгө ногоон Оюу толгой
 Ард түмний минь эрдэнийн бэлгэдэл
 Алт зэсэн Оюу толгой

Ирэх цагийн өнгийг тольдсон
Эрин зууны бүтээл үндрүүлсан
Даяар олныхоо алдрыг дуурсгасан
Даян дэлхийн сонорыг мялаасан
 Өмнийн говийн эрдэнэсийн өлгий
 Өнгө ногоон Оюу толгой
 Ард түмний минь эрдэнийн бэлгэдэл
 Алт зэсэн Оюу толгой

Хамаг ардынхаа амьдралыг ивээсэн
Ханбогдынхоо алдрыг мандуулсан
Хатан дэлхийгээс халгиж ундарсан
Хотол Монголынхоо хөгжлийг тэтгэсэн
 Өмнийн говийн эрдэнэсийн өлгий
 Өнгө ногоон Оюу толгой
 Ард түмний минь эрдэнийн бэлгэдэл
 Алт зэсэн Оюу толгой



Lyrics by Ambassador G.Batsukh

Music by L.Balkhjav, Honorary Cultural Artist of Mongolia

Oyu Tolgoi

Bursting from a thousand aeons,
taking form throughout history,
my ancestors kept it in safety,
inherited it sacredly from my forebears.

A cradle of jewels in the southern Gobi,
is verdant Oyu Tolgoi.

A symbol of my people's treasure
is Oyu Tolgoi, golden and copper.

Reflecting the appearance of the times to come,
bringing forth the works of century current,
broadcasting all around the fame of my people,
anointing the ears of the world.

A cradle of jewels in the southern Gobi,
is verdant Oyu Tolgoi.

A symbol of my people's treasure
is Oyu Tolgoi, golden and copper.

Blessing the lives of all our people,
proclaiming the fame of the Khanbogd,
spurting out from Mother Earth,
boosting Mongolia to progress.

A cradle of jewels in the southern Gobi,
is verdant Oyu Tolgoi.


A symbol of my people's treasure
is Oyu Tolgoi, golden and copper.

Translated by Simon Smith



Их өмөө

*Түнэр харанхуйгаас наашлан буй үүрийн гэгээ
Их говийн хаяанд мэлсхийх алтан наран
Амьдрал тэтгэсэн их цацрал*



The golden morning of the Gobi

*Darkness receding, dawn breaking
The golden rising sun washing through the Gobi
Awaking the soul therein*

Хулангийн тоос

Их говийн хангал эзэн хулангийн тоос татсан тэнгэр
Тэнгэрийн дор амьдрал урагш тэмүүлсэн эрчим

Гоцлооч Б.Ганхөлөг (яруу хэнгэрэг)





Dust of Khulan

*The wild masters of the great Gobi, the Khulan
Fill the skies with dust
Life under the heavens
Make a leap forward*

Solo B.Ganhulug (timpani)



Зэрэмээ

Монголын говийн зэрэглээ

Монгол хүний эрин галавын дурдатгал

Бас хүсэл, бас мөрөөдөл, бас эргэлзээ, бас итгэл

The mirage

*A mirage in the Gobi is a Mongolian memory of ages
past, of wishes, of dreams, of doubts and of trust*



Уналз

Бидний эс жолоодох хүчин



Ugalz *The Gobi sandstorm*

The power that is beyond us



Сэтгэлийн үнээс

*Монгол хүний эх нутгаа гэх чин хайрын дуулал,
Морин дэл дээр хийсэх сэтгэлийн түмэн хэлхээ*

Гоцлооч Н.Жигжиддорж (морин хуур)



From the bottom of my heart

*A hymn of Mongolian's true love for the homeland
A chain of many hearts drifting over horse's mane*

Solo N.Jigjiddorj (morin khuur)



Ханбогдын ЭШИИЛЭН

Намуун шаргал говь
Яасан баян тансаг
Яасан дэлгэр уужим
Ямар их ивээл
Ямар их өршөөл

Гоцлооч

Г.Гэрэлцэцэг (флейт)
Э.Оюунтуяа (ятга)



Khanbogd melody

*The serene golden Gobi
How rich are thou
How vast are thou
What a grace
What a mercy*

*Solo G.Gereltsetseg (flute)
 E.Oyuntuya (yatga)*



Эрин цаг

Хүн эх орноо гэдэг
Эх орон нь хүнээ тэтгэдэг
Эрдэнээ өгсөн говь минь
Эрин цагийн дуулал минь



New Era

*A man – for the country
The country – for the man
Oh my Gobi, which giveth its treasure
Oh my hymn, the song of my contemporaries*



A large truck is shown from the side, carrying a load of white sacks secured with straps. The truck is on a paved road that stretches into the distance under a sunset sky. Another smaller truck is visible further ahead on the road. The text is overlaid on the left side of the image.


“Оюу толгой” ХХК-ийн тухай

“Оюу толгой” бол Монгол улсын хамгийн том зэс, алтны компани бөгөөд Монгол улсын Засгийн газар, “Туркойз Хилл Ресурс” болон “Рио Тинто” компани хоорондын стратегийн түншлэл юм. Монголын өмнийн говьд үйл ажиллагаа явуулдаг “Оюу толгой” компани 2013 оны долдугаар сард анхны зэсийн баяжмалаа экспортод гаргасан билээ. “Оюу толгой”-н менежментийг гүйцэтгэгч “Рио Тинто” компани “Оюу толгой”-г дэлхийн хамгийн орчин үеийн уурхай болгохын төлөө олон улсын тэргүүн туршлага, орчин үеийн дэвшилтэт техник, технологиор хөрөнгө оруулж байна. “Оюу толгой” аюул осолгүй ажлын байр бий болгож, хүрээлэн буй орчноо хамгаалах шинэ стандарт тогтоохын төлөө ажилладаг.



About Oyu Tolgoi LLC

Oyu Tolgoi LLC, Mongolia's largest copper and gold mining company, is a strategic partnership between the Government of Mongolia, Turquoise Hill Resources and Rio Tinto. Located in the South Gobi, Oyu Tolgoi commenced shipment of product to customers in July 2013. Oyu Tolgoi is managed by Rio Tinto, which is investing global expertise and cutting-edge technology to help develop Mongolia's mining industry and ensure Oyu Tolgoi is one of the world's most advanced mines. For Oyu Tolgoi, nothing matters more than safety. The business operates under the principle that if a job cannot be done safely, it will not be done at all.



Нацагийн Жанцанноров

Монголын орчин үеийн нийгэм, соёлын нэрт зүтгэлтэн, хөгжмийн зохиолч, хөгжим судлагч Н.Жанцанноров нийтийн дуу, дуулаачийн болон дан хөгжмийн, кино, балетын олон зуун дуу, хөгжмийн бүтээл туурвисан.

Хөгжмийн толь бичиг, судалгааны 8 ном, 10 цомог хэвлүүлсэн. Урлаг судлалын ухааны доктор, профессор, Монгол Улсын төрийн шагнал 1989, 2000 онд 2 удаа хүртсэн. 2005 онд Монголын урлагийн дээд цол Ардын жүжигчин цол хүртсэн.

Jantsannorov Natsag

Musician and composer Jantsannorov is a national icon at the centre of contemporary Mongolian art and culture. He is the author of several hundred musical compositions, including for film and ballet.

He holds a PhD in art and has published eight musical studies and almanacs, alongside his ten albums. He has twice been awarded State Honour, in 1989 and 2000. In 2005, he was named People's Artist, the highest honour for a member of the Mongolian arts community.



